

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/005/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энхдэлгэр

Утас: 99002291 Цахим хаяг: enkhdelgerg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

ЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Р.МӨНХБАЯР ТАНАА

2025. 03.24 № 121
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Жаргалан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.7, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.5, 41.2.7 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Бууны албан татвар 625.0 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 206.5 мянган төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 2,871.2 мянган төгрөгөөр тус тус тасарсан,
- Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 206,219.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

8225020349

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд зохион байгуулсан сумын 100 жилийн ойн арга хэмжээний зардалд 100,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын захирамжаар олгосон байна.

Засгийн газрын 2024 оны 231 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмсэн, мөн оны 83 дугаар тогтоолоор Төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгожээ.

“Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор нийт 4 орон тоо нэмэгдсэн байна.

Сумын Орон нутгийн төсвийн орлогыг 262,784.7 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 360,151.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 97,366.5 мянган төгрөгөөр буюу 137.1 хувьтай биелүүлсэн байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 1,263,321.4 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 397,279.8 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Сумын орон нутгийн төсвөөс Ерөнхий боловсролын сургуульд 29,274.7 мянган төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэгт 41,859.7 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн төвд 23,100.3 мянган төгрөгийн, Соёлын төвд 53,653.4 мянган төгрөгийн тогтмол зардлын санхүүжилтийг тус тус дутуу олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сан, сумын ойн хандив болон бусад эх үүсвэрээс 265,385.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г. ГҮНЖИДМАА

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,096,787.2	1,010,977.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	501,142.9	324,815.0
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	188,262.4	267,908.1
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	379,650.2	390,522.2
36	НӨӨЦИЙН БАРАА	4,246.8	4,246.8
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	23,485.0	23,485.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,011,411.4	4,141,371.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,011,411.4	4,141,371.4
39200	Биет хөрөнгө	3,263,262.1	3,393,152.1
39300	Биет бус хөрөнгө	748,149.3	748,219.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,108,198.6	5,152,348.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	58,991.2	227,360.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	58,991.2	227,360.2
41300	Өглөг	58,991.2	227,360.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,049,207.4	4,924,988.2
51	Засгийн газрын хувь оролцоо	5,049,207.4	4,924,988.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	393,328.6	393,328.6
51200	Хуримтлагдсан үр дүн	4,287,090.5	4,162,871.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	368,788.4	368,788.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,108,198.6	5,152,348.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,439,300.6	2,004,802.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	251,242.4	359,361.2
110	Орлогын албан татвар	167,346.6	312,075.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	180,826.0	342,880.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(13,479.4)	(30,805.0)
113	Хөрөнгийн албан татвар	51,247.9	40,679.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	32,647.9	6,605.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	641,449.8	449,046.6
120	Нийтлэг татварын бус орлого	641,449.8	449,046.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,546,608.4	1,196,394.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,942,944.5	1,928,579.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,769,435.8	1,928,579.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,370,721.4	1,877,480.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	386,868.4	633,809.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,099.4	79,456.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	385,980.3	532,558.5

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	70,376.8	80,547.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	93,781.0	65,348.2
2107	Томилолт, зочны зардал	12,815.0	16,122.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	155,418.7	285,921.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	217,381.8	183,716.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,398,714.4	51,098.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	173,508.7	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	496,356.1	76,223.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,985.0	202,171.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	494,371.1	(125,947.9)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,302,209.4	2,005,963.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	251,242.4	359,361.2
110	Орлогын албан татвар	167,346.6	312,075.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	180,826.0	342,880.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(13,479.4)	(30,805.0)
113	Хөрөнгийн албан татвар	51,247.9	40,679.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	32,647.9	6,605.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,806.7	1,322.3
1181	Газрын төлбөр	2,761.9	5,283.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	27,079.4	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	448,124.6	450,207.8
120	Нийтлэг татварын бус орлого	448,124.6	450,207.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,602,842.4	1,196,394.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,891,510.8	1,898,722.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,891,510.8	1,898,722.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,436,562.3	1,847,624.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	499,349.6	780,733.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,765.5	111,807.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,595.5	420,257.2
2104	Хангамж, бараа материалын зардал	223,272.2	197,896.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,305.0	73,916.4
2107	Томилолт, зочны зардал	12,815.0	16,122.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	505,689.5	187,739.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,770.0	59,151.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,454,948.5	51,098.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	410,698.6	107,241.1
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	251,266.7	213,419.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	251,266.7	213,419.0
2200	Дотоод эх үүсвэрээр	251,266.7	213,419.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(251,266.7)	(213,419.0)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(78,485.0)	(70,150.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	78,485.0	70,150.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	80,946.9	(176,327.9)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	420,196.0	501,142.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	501,142.9	324,815.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,554,836.3	0	4,554,836.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,554,836.3	0	4,554,836.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	494,371.1	0	494,371.1
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,049,207.4	0	5,049,207.4
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,049,207.4	0	5,049,207.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,728.7	0	1,728.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,050,936.1	0	5,050,936.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	-125,947.9	0	-125,947.9
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,924,988.2	0	4,924,988.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,987,314.7	1,624,562.8	362,751.9	81.7%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,587,148.4	1,367,940.8	219,207.6	86.2%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,535,251.2	1,316,842.1	218,409.1	85.8%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	624,310.0	618,849.1	5,460.9	99.1%
210101	Үндсэн цалин	213,000.0	275,135.5	(62,135.5)	129.2%
210102	Нэмэгдэл	296,300.0	266,687.3	29,612.7	90.0%
210104	Урамшуулал	81,410.0	40,582.0	40,828.0	49.8%
210105	Гэрээт ажлын хөлс	33,600.0	36,444.3	(2,844.3)	108.5%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,000.0	71,271.7	6,728.3	91.4%
210201	Тэтгэврийн даатгал	53,040.0	48,536.1	4,503.9	91.5%
210202	Тэтгэмжийн даатгал	6,240.0	5,707.8	532.2	91.5%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,992.0	2,840.5	2,151.5	56.9%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,248.0	2,801.0	(1,553.0)	224.4%
210205	Эрүүл мэндийн даатгал	12,480.0	11,386.3	1,093.7	91.2%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	549,168.7	393,701.0	155,467.7	71.7%
210301	Гэрэл, цахилгаан	32,740.0	22,073.2	10,666.8	67.4%
210302	Түлш, халаалт	508,628.7	364,327.8	144,300.9	71.6%
210303	Цэвэр, бохир ус	7,800.0	7,300.0	500.0	93.6%
2104	Хангамж, бараа материалын зардал	58,191.0	56,672.2	1,518.8	97.4%
210401	Бичиг хэрэг	8,450.0	8,358.9	91.1	98.9%
210402	Тээвэр, шатахуун	30,200.0	30,161.2	38.8	99.9%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000.0	1,214.8	785.2	60.7%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,541.0	16,937.4	603.6	96.6%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	107,000.0	92,916.4	14,083.7	86.8%
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,000.0	19,000.0	-	100.0%
210604	Урсгал засвар	88,000.0	73,916.4	14,083.7	84.0%
2107	Томилолт, зочны зардал	19,300.0	16,122.5	3,177.5	83.5%
210702	Дотоод албан томилолт	19,300.0	16,122.5	3,177.5	83.5%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,655.0	8,540.6	17,114.4	33.3%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,600.0	6,565.5	15,034.5	30.4%
210803	Даатгалын үйлчилгээ	800.0	-	800.0	0.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	165.0	-	165.0	0.0%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90.0	-	90.0	0.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500.0	880.0	620.0	58.7%
210807	Газрын төлбөр	1,500.0	1,095.1	404.9	73.0%

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,626.5	58,768.6	14,857.9	79.8%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,126.5	57,288.6	14,837.9	79.4%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500.0	1,480.0	20.0	98.7%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,897.2	51,098.7	798.5	98.5%
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,897.2	51,098.7	798.5	98.5%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	26,997.2	44,997.2	(18,000.0)	166.7%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,100.0	-	18,100.0	0.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,800.0	6,101.5	698.5	89.7%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	253,166.3	186,472.0	66,694.3	73.7%
223001	Бусад хөрөнгө	253,166.3	186,472.0	66,694.3	73.7%
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	147,000.0	70,150.0	76,850.0	47.7%
230001	Эргэж төлөгдөх зээл	147,000.0	70,150.0	76,850.0	47.7%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,987,314.7	1,632,993.0	354,321.7	82.2%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,789,937.0	1,571,708.2	218,228.8	87.8%
320001	Орон нутгийн төсвөөс	1,610,961.9	1,400,608.0	210,353.9	86.9%
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	178,975.1	171,100.2	7,874.9	95.6%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	197,377.7	61,284.7	136,093.0	31.0%
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,560.0	1,189.6	370.4	76.3%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,818.4	60,095.1	6,723.3	89.9%
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	128,999.3	-	128,999.3	0.0%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	149,638.5	(149,638.5)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	158,068.7	(158,068.7)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	215,487.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	215,487.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	147,300.50
2104	Хангамж, бараа материалын зардал	11,312.78
210402	Тээвэр, шатахуун	11,312.78
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	135,605.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	135,605.00

ГАА-2025/005/НА-СТА-ТТЗ

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	382.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	382.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,186.57
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	68,186.57
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	68,186.57
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	215,487.07
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	215,487.07
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,265.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,623.03
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	365.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	56,234.04
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар залруулга хийгдээгүй.

3.1.1 Залруулагдаагүй нийт 151.6 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшингөөс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 151.6 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

3.1.2 Харьяа байгууллагууд

Жаргалан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 1 Суурин дулаан аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Хязгаарлалттай”,дүгнэлт, Суурин дулаан ААТҮГ-т аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

3.1.3 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 245.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 2 алдааг залруулж, 82.4 сая төгрөгийн 5 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

3.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 166.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 4 алдааг залруулж, 123.8 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлж, 0.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 123.4 сая төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 151.6 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлж зөрчил арилгах 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

3.3 Албан шаардлага

1. Орон нутгийн орлого төлөвлөснөөс бууны албан татвар 0.6 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 0.2 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 2.9 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" Жаргалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт залруулагдаагүй 208.2 сая төгрөгийн 11 зөрчил илэрч, 0.4 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 207.7 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгаж, цаашид давтан гаргахгүй байх 9 заалт албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн. Энэ Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн төсвөөс 397.3 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

ГАА-2025/005/НА-СТА-ТТЗ

Сумын орон нутгийн төсвөөс Ерөнхий боловсролын сургуульд 29.3 сая төгрөгийн, Цэцэрлэгт 41.8 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төвд 23.1 сая төгрөгийн, Соёлын төвд 53.7 сая төгрөгийн тогтмол зардлын санхүүжилт дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16-т "төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох; 41 дүгээр зүйлийн 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Говь-Алтай аймгийн Жаргалан Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолтой нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хуваарийн дагуу нэгж байгууллагуудад санхүүжилтийг олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залуулсан		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жаргалан сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Жаргалан сумын Засаг даргын Тамгын газар	4	166,885.40			4	166,885.40	4	166,885.40	-	-	-	-
Жаргалан сумын Орон нутгийн хөгжлийн сан Суурин дулаан ААТҮГ	2	245,749.40			2	245,749.40	2	245,749.40	-	-	-	-
Дүн	6	412,634.80	0	0	6	412,634.80	6	412,634.80	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жаргалан сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	1	-	3	151,590.8	2	3,702.7	1	147,888.1	-	-	-	-
Жаргалан сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

